



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/449

Мөрөн сум

Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5-ийн "а", 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42.1.3, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын 3.3.28 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 38 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв" байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төслийн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дэд хорооны ахлагч: Ц.Баттогтох-Аймгийн Засаг даргын орлогч

Дэд хорооны нарийн бичгийн дарга: Д.Цэцэгмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: С.Нарантуяа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Азжая- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Эрдэнэхуяг- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Д.Баасансүрэн- Боловсрол, соёл, урлагийн газрын хэлтсийн дарга

М.Үүрийнбаяр- Эрүүл мэндийн газрын дарга

Д.Мягмарсүрэн-Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Ч.Дашбаяр-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Л.Юмжирдулам- Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, Эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын дарга

Б.Ганзориг-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Оюун-Эрдэнэ-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын нарийн бичгийн дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

А.Оюунчимэг- Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн

Ч.Лхагвасүрэн- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажлын зураг гаргах, барилга барих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төвд ажиллах боловсон хүчний хэрэгцээг гарган сонгон шалгаруулах, мэргэшүүлэх асуудлыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, төслийн удирдах хороотой хамтран шийдвэрлэх, Төслийн хүрээнд хийж буй судалгаа, зөвлөх үйлчилгээний ажилд дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангах, Төслийн ажлын явц, тайлан, тулгамдсан асуудлын талаар улирал тутам хэлэлцэж, Төслийн удирдах хороонд тайлагнах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллахыг дэд хорооны дарга /Ц.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Төслийн хэрэгжилт болон барилгын ажилтай холбоотой иргэдийн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлүүлэх асуудлыг хариуцан ажиллахыг төслийн дэд хорооны гишүүд Ч.Дашбаяр, Ц.Оюун-Эрдэнэ, Д.Баасансүрэн нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the province and the title of the official. The signature is stylized and extends across the stamp.

Л.ГАНБОЛД